

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг-Ус ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2025/009/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, Тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.08.13 № 324

танай _____ ны № _____ т

**“ТЭШИГ-УС” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Э.ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Компани ТУЗ-ын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01 тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тайлант оны нийт орлогыг 542.6 сая төгрөг, нийт зардлыг 542.6 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ нь гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 488.2 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт зардлын гүйцэтгэл 476.9 сая төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь 9.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Булган аймгийн Тэшиг сумын орон нутгийн төсвөөс шинээр 84.3 сая

632502627

төгрөгөөр халаалтын зуух худалдан авч суурилуулсан байна.

“Тэшиг-Ус” ОНӨААТҮГ-нь 2024 онд “Буурлын хөндий” ХХК, Б.Батзориг, Г.Баттулга нартай нүүрс худалдах, худалдан авах гэрээг байгуулж 1 тоон нүүрсийг 190.0 мянган төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж нийт 975.2 тоон буюу 185.3 сая төгрөгийн нүүрс худалдан авч Тэшиг сумын төсвийн 5 байгууллага, 22 аж ахуй нэгж, 2 өрхийг дулаанаар хангасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	80,457,996.78	74,310,382.69
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	133,930,849.80	192,072,618.09
Нийт хөрөнгийн дүн	214,388,846.58	266,383,000.78
Нийт өр төлбөрийн дүн	78,107,029.18	36,671,600.49
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	136,281,817.40	229,711,400.29
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	214,388,846.58	266,383,000.78
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	423,535,557.82	488,334,529.33
Үйл ажиллагааны зардлын дүн	409,078,743.89	479,234,511.93
Үйл ажиллагааны үр дүн	14,456,813.93	9,100,017.40
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	14,456,813.93	9,100,017.40
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		136,281,817.40
Тайлант оны үр дүн		9,100,017.40
Эцсийн үлдэгдэл		229,711,400.29
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	432,592,840.21	548,908,959.15
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	442,357,202.13	548,067,421.21
Үйл ажиллагааны ЦМГ	-9,764,361.92	841,537.94
Хөрөнгө оруулалтын ЦМГ		-108,000.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-9,764,361.92	733,537.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,822,789.56	12,058,427.64
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,058,427.64	12,791,965.58
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал		
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Гурав. Аудитын илрүүлэлт

Илрүүлэлт-1:

Аудитаар нийт 129,425.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 6,204.0 мянган төгрөгийн албан шаардлага, 123,221.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 113.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,488.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.2 Албан шаардлага

1. Шилэн данстай холбоотой.

Илрүүлэлт:

Шилэн дансны 170 мэдээлэл оруулахаас 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

2. үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт:

Уурын зуухны насосын ороолт, хөдөлгүүрийн ороолт тасарч гэмтсэн солих шаардлага үүссэн ч инженерийн техникийн тодорхойлолтгүйгээр 6.2 сая төгрөгийн ороолтыг Орхон аймгаас худалдан авч ороолгосон нь техникийн тодорхойлолтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг мөрдөж ажиллаагүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой.

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийг коджуулаагүй. /Үндсэн хөрөнгийн баар кодоор хэвлэж хөрөнгө бүр дээрээ наах/
Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг баар кодоор хөрөнгө эзэмшигчээр коджуулах.

1. Хангамжийн материалтай холбоотой.

Илрүүлэлт:

Хангамжийн материалын 113.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг коджуулаагүй. /Үндсэн хөрөнгийн баар кодоор хэвлэж хөрөнгө бүр дээрээ наана./	1	123,107.6					1	123,107.6				
Хангамжийн материалын 113.5 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй.	1	113.5					1	113.5				
Уурын зуухны насосын ороолт, хөдөлгүүрийн ороолт тасарч гэмтсэн солих шаардлага үүссэн ч инженерийн техникийн тодорхойлолтгүйгээр 6.2 сая төгрөгийн ороолтыг Орхон аймагаас худалдан авч ороолгосон.	1	6,204.0			1	6,204.0						
	3	129,425.1			1	6,204.0		123,221.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Шилэн дансны 170 мэдээлэл оруулахаас 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн			1	0		
Дүн			1	0		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>						
Дүн						
Нийт дүн						